



ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 22

Мандалговь

“Сум хөгжүүлэх сан”-гийн  
төслийн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн 22.1.9, 24 дүгээр зүйлийн 24.1, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын хавсралтын 3.3 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:


1.“Сум хөгжүүлэх сан”-аас 2021 онд олгох зээлийн төсөлд баримтлах чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх бодлого, аймаг, sumaас дэвшүүлсэн зорилт, хөтөлбөр, төлөвлөгөөнүүдтэй уялдуулан орон нутгийн давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгон ажлын байрыг нэмэгдүүлж ажиллахыг төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлд үүрэг болгосугай.

3. Батлагдсан чиглэлийг баримтлан зээлийг олгож, үр дүнг тооцон, зээл, зээлийн хүүг хугацаанд нь төвлөрүүж тайлагнаж ажиллахыг төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн дарга (С.Бат-Оргил)-д даалгасугай.



Сумын Иргэдийн Тэргүүлэгчдийн Хурлын  
2021 оны 13 сарын 22.-ны өдрийн  
22. тоот тогтоолын хавсралт



**САЙНЦАГААН СУМЫН “СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН”-ААС 2021 ОНД  
ОЛГОХ ЗЭЭЛИЙН ТӨСӨЛД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ**

№	Салбар	Бодлогын зорилтын үндэслэл	Шинээр хөгжүүлэх болон өргөжүүлэх үйлдвэр, үйлчилгээний чиглэл	Санхүүжилтийн эх үүсвэр
1	<b>Нэг. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ ҮЙЛДВЭР- ЛЭЛИЙН ЧИГЛЭЛ</b>	3.2.1.1.	Хүнсний худалдаа эрхлэгч иргэн, ААНэгжид хөргүүр бүхий автоматжуулсан махны зоорь	CXC
2		3.2.1.1.	Зөвшөөрөгдсөн бүсэд байршилтай эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан мал нядалгааны цэгийг бий болгохыг дэмжинэ.	CXC
3		3.2.1.2.	Хүн амын өвөл, хавар, зуны хэрэгцээний махны нөөцийг бүрдүүлж, махны хангамжийг нэмэгдүүлэх	CXC
4		3.2.1.4.	Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх малчин өрхийг дэмжинэ.	CXC
5		3.2.1.5.	Ноос, ноолуур, арьс шир боловсруулах бичил үйлдвэр	CXC
6			Мах болон малын гаралтай дайвар бүтээгдэхүүн боловсруулах бичил үйлдвэр	CXC
7		3.2.1.6	Зуны хүлэмжийн аж ахуйг 240 мкв, өвлийн нарлаг хүлэмжийг 120 мкв, төмс хүнсний ногоог 0,5 га-аас доошгүй талбайд тус тус дэмжинэ.	CXC
8		3.2.1.8.	Тариалан эрхлэгчдийг зоорьтой болгоход дэмжинэ.	CXC
9		3.2.2.5.	Стандартын шаардлага хангасан 2 -оос доошгүй мах, сүүний чиглэлийн бух болон хосолмол ашиг шимтэй бусад төрлийн малыг бойжуулах	CXC
10	<b>ХОЁР: ХӨНГӨН ҮЙЛД ВЭРИЙН ЧИГЛЭЛ</b>	3.2.1.3.	Орон нутгийн онцлогтой инноваци шингэсэн брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн дотоод, гадаадын зах зээлд нийлүүлэх хоршоо, ААНыг дэмжинэ.	CXC
11			Ахуй үйлчилгээний төрөл бүрийн уламжлалт болон дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлсэн бичил үйлдвэрүүд	CXC
12		5.1.2.	Хоёрдогч түүхий эдийг ангилан ялгаж, хог хаягдлыг дахин боловсруулах бичил үйлдвэрлэлийг дэмжинэ.	CXC
13	<b>ГУРАВ: ХУДАЛДАА ҮЙЛЧИЛ- ГЭЭНИЙ ЧИГЛЭЛ</b>	2.1.3.5.	24 цагаар ажиллах эмийн санг дэмжинэ.	CXC
14		5.1.1.3	Гэр хорооллын өрхүүдэд зориулагдсан сайжруулсан ариун цэврийн байгууламжийн үйлдвэр	CXC